



## СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

### Сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт гаргах тухай

Монгол улсын “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 11.2.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан тушаал, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн ажлын алба, СЭМҮТ-ийн 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хамтран ажиллах тухай санамж бичиг, СЭМҮТ-ийн Ерөнхий захирлын 2014 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 13 тоот тушаалуудыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Шүүгчид нэр дэвшигчдийн сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт гаргах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Н.Туяа /Ерөнхий зөвлөх, амбулаторийн эрхлэгч, зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор/

Гишүүд: Д.Дэжидмаа /Сэтгэцийн тэргүүлэх зэргийн эмч/

Б.Туяа /Сэтгэцийн эмгэг судлаач, ахлах зэргийн эмч/

Хоёр. Комиссын дарга гишүүдэд даалгах нь:

2.1. Шүүгчид нэр дэвшигчдэд сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлтийг гаргах

2.2. Шаардлагатай тохиолдолд сэтгэц эмгэг судлалын шинжилгээний аргуудаар оношлон дүгнэлт гаргах

2.3. Тус төвд хэвтэн эмчлүүлж байсан, сэтгэцийн эмчид үзүүлж байсан тухай асуудалтай нэр дэвшигчдийн нотлох баримтуудыг цуглуулан дүгнэлтэнд тусгах

Гурав. Шүүгчид нэр дэвшигчдийн сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд өдөр тутмын мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /О.Ганчулуун/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг СТХНХЭ дэд захирал /О.Баатаржав/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

00 341